

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

НИЙТЛЭЛЧ НАЦАГИЙН ДАВААДАШИЙН ШОГ, ХОШИН
НИЙТЛЭЛИЙН УРАН ЧАДВАРЫН АСУУДАЛД

Н.Мөнхзориг*

*“Идэр” ихсургуулийн Монголхэл, Сэтгүүлзүйнтэнхимийнэрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүрүг: шог, хошин нийтлэл; “Хүмүүжилжигшил”, “Матар”, “Тоншуул” сэтгүүл; шог, хошин нийтлэлийн сэдэв, бичлэгийн төрөл зүйл; шог, хошин нийтлэлчдийн уран чадвар

Сэтгүүл зүй судлал манай оронд үүсч хөгжөөд төдийлөн удаагүй бөгөөд 1960-аад оноос шинжлэх ухааны дүр төрхдөө орсон байна. Энэ үеэс манай шог, хошин зохиол, нийтлэлийг тоймлон судалсан эрдэм шинжилгээний өгүүллүүд гарч эхэлжээ. 1960-1970-аад оны үед шог, хошин зохиол зогсонги байдалд орж, онч биш тусгалтай хөндий хуурай бичлэг давамгайлж, хэмжээний хувьд жижгэрсэн, шүлэглэх, чамирхах гэж хэт хөөцөлдөх болсон зэрэг дутагдлыг Д.Даржаа, Б.Бааст, Л.Ванган, Ш.Гаадамба, С.Лувсанвандан, Л.Содов, Б.Содном, Ц.Тогооч, Д.Цэнд, Т.Юмсүрэн, Ц.Дамдинсүрэн, О.Жигмэдготов, Д.Сэнгээ, Н.Цэенжав, Г.Дэлэг нар судалгаа шинжилгээний бүтээлүүддээ шүүмжилсэн байна. Тэд шог, хошин нийтлэл, зохиолын аль алийг нь судлагдахуунаа болгосон байдаг.

Харин 1980-аад оны дунд үеэс хойш шог, хошин нийтлэлийн

сэдэв өргөжиж, бичлэгийн төрөл, зүйлийн агуулга, хэлбэр баяжиж, хамрах хүрээ нь тасралтгүй гүнзгийрэн тэлжээ. Гэвч Монголын нийгэмд олон жилийн турш бугшсан алдаа дутагдлыг илчлэн дэлгэж, бүрмөсөн илааршуулж чадахгүй байна гэж судлаач Х.Сампилдэн-дэв, Л.Түдэв, Ц.Хасбаатар, Шаг.Цэнд-Аюуш, Д.Өлзийбаяр, Д.Хүү, Ши.Цэнд-Аюуш, До.Цэнджав, Р.Нарантуяа нар дүгнэсэн. Мөн ардчиллын он жилүүдийн шинэ үзэгдэл болсон буюугаар санавлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах, нэр хүнд, эрхмэдлийн төлөөх тэмцэл зэрэг нь хүн чанарыг үгүй хийж байгааг шог, хошин нийтлэлчид энэрэх ёсгүйг судлаачид сануулжээ.

Ялангуяа доктор, профессор Ш.Гүндалай¹, шинжлэх ухааны доктор, профессор Л.Норовсүрэн² нар шог, хошин зохиол, нийтлэлийг дорвитой судалжээ. Ингэхдээ Ш.Гүндалай уран зохиолын талаас нь нилээд анхаарч, шог, хошин өгүүллэгээр дагнасан бол Л.Норовсүрэн сэтгүүл зүйн бичлэгийн хурц дайчин зүйлүүд болох шог найруулал, улс төрийн шогийг судалсан байна. Түүнчлэн судлаач Л.Норов-

сүрэн элэглэл, наргиа, шог яриа (онигоо), хошин тайлбар, хоч шүлэг зэрэг бичлэгийншог, хошин бэсрэгзүйлийг ч анхаарч судалжээ. Гэхдээ шог, хошин нийтлэлчдийн бүтээлийн дотоод уран чадварт онол, арга зүйн үүднээс ул үндэстэй дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгсөн судал-гааны бүтээл тун ховор байгааг дурьдах нь зүйтэй.

1990 оноос хойшх үеийн «Тоншуул» сэтгүүлийг Н.Даваадаш, Б.Цэнддоо, Ц.Доржготов, И.Цэрэн-жамц, Д.Баясгалан, Л.Ожгоош, Н.Пүрэвсүрэн, М.Гүрсэд, А.Амарсайхан, Шаг.Цэнд-Аюуш, Б.Батчимэг, С.Баярхүү, З.Ганболд, Ю.Санжаагончиг нарын шог, хошин нийтлэлч, сэтгүүлчидгүйгээр төсөөлөхийн аргагүй.

1990 оноосхойшхи үеийн«Тоншуул»сэтгүүлийннэггөлтөлө ө-лөгчболСоёлын гавьяат зүтгэлтэн Нацагийн Даваадашюм.Тэрээр шог найруулал, бичиж гаршсан нэгэн бөгөөд өнөө цагийн нийгмийн бурангуй тогтолцоо, бусармаг үзэгдлийг чимхсэн нийтлэлүүдээ туссэтгүүлд хэвлүүлжээ. Тухайлбал, «Манай сумын ардчилал» (2004, №10), «“Янхантай улс төр”-ийн шинэ лекц» (2006, №11), «Яруу найргийн тухай шинэ номлолын удиртгал» (2006, №12), «“Найраа” гэж» (2002, №11, 12), «Хүн гэж хэнийг нэрлэх вэ?» (2002, №13), «УИХ-д лав “өө” байхгүй» (2002, №15), «Намын сэдвийн хамелеон тэмдэглэл» (2006, №05), «Хүн бол мөнгөний амьтан мөн» (2004, №18), «Өвлийн өвгөний томилгоо» (2004, №23,24), «Хошигнол» (2002, №14), «Улсын наадмын шинэ менежмент» (2006, №13, 14), «Очир лам» (2006, №05), «Архи эрхэмд өчихүй дор» (2006, №11), «Орчин цагийн “Топ” ерөөл» (2004, №23, 24),

«Үхсэний дараах улирал» (2006, №13, 14) зэргийг дурдаж болно.

Н.Даваадаш «УИХ-д лав өө байхгүй» шог найруулалдаа 2000-2004 оны УИХ-ыг бараг дангаараа бүрдүүлж байсан МАХН-ынхан ямар ч эсэргүүцэл, санал шүүмжлэлгүй бага ангийн сурагчид шиг ярсхийтэл зэрэг гар өргөн хууль баталдаг үйл ажиллагааг шүүмжилжээ. «Дөрөвхөн гишүүнээс бүрдсэн сөрөг хүчинтэй УИХ арга ч үгүй байсан биз. Ийм УИХ лав өөгүй байсан биз» хэмээн егөөджээ. Энэ санаагаа дэлгэрүүлж: «...Өнөөдөр УИХ-ын тойм харж суухад хүртэл сэтгэл дэнслэх, эргэцүүлж бодох юмгүй амар болж. Заримдаа телевизээ асааж цахилгаан гарздах ч явдалгүй УИХ хуралдлаа гэв үү “За 100%-ийн саналаар батлаа биз дээ. Манай их хурал ямар “өө” гаргах биш, амьдралд яв цав тохирох л юм гаргасан даа” гэж бодосхийгээд шууд “давсанд явчих” жишээтэй... Ер нь “өөгүй” төр засгийнхаа үг ярианд шүтэж өлссөн ч гэсэн өөх үмхчихсэн юм шиг, өвдөж байсан ч мөнхийн ус уучихсан юм шиг харайна гэдэг сайхан» гэжээ. Энэ шог найрууллын гол санаа нь УИХ дахь МАХН-ын бүлэг сөрөг хүчингүй амар жимэр байгаа нь цаагуураа төрийг алдаагаа харах чадваргүй болгож, хямрал руу хөтөлж байна хэмээн шүүмжилсэнд оршино. Уг шог найруулалд ямар ч сөрөг хүчингүй УИХ «өө»-гүй биш, дандаа «өө»-тэй гэсэн санаа нэвт шингэжээ.

Тэгвэл «Найраа гэж» шог найруулалдаа Монголд найраагүй юм үгүй болсныг дурдаад найраануудыг жишээ баримттай тоочсон бол «Хүн бол мөнгөний амьтан мөн» шог найруулалдаа хүн бол олон сэтгэгчдийн тодорхойлсноор байгаль болон нийгмийн амьтан аль нь ч биш, гагцхүү

мөнгөний амьтан мөн гэж «баталжээ». Учир нь мөнгөгүй хүн бол хүн биш адгийн шаар, мөчөө тас цохиулсан амьтнаас долоон дор болдгийг шоглосон байна.

Түүний уран бүтээлийг судлаач Б.Мөнхбаяр «Н.Даваадашийн шог найруулал, хошин зохиолууд нь нийгмийг эрүүл саруул байлгах, хүмүүсийн харилцаанаас үүдэн гардаг зан суртахууны олон талыг уран ёгт, егөө дүрслэлийн туслалцаатай ил шууд өгүүлдгээрээ онцлог юм»³ гэж дүгнэсэн байдаг.

Ардчилал, улс төр, хүний эрх, урлаг уран сайхан, авлига хээл хахууль, УИХ ба нам эвсэл, хүн ба мөнгө, баяр наадам, архи тамхи, зах зээлийн үеийн хүний мөс чанар, залхуу хойрго байдал Н.Даваадашийн шог, хошин нийтлэлийн үндсэн сэдэв байв. Тэрээр даацтай, гүн гүнзгий утга агуулгатай бичдэг, шог найруулал, шог өгүүллэг, хошин ерөөл зэрэг олон төрөл, зүйлээр нийтлэлээ туурвидаг сэтгүүлч юм.

Авлига, хээл хахуулийн асуудалд хошин шогчид онцгой анхаарч байв. 1990 оноос хойш энэ сэдвээр олон нийтлэл бичигджээ. Гэхдээ авлига, хээл хахууль нь далд явагддаг үзэгдэл тул нэр ус, албан тушаал заасан бус, харин сэтгүүлчийн уран зохиомж бүхий ерөнхий нийтлэл «Тоншуул»-ын хуудаснаа хэвлэгдэж байв. Тухайлбал, Н.Даваадашийн «Үхсэний дараахь

улирал» (2002, №13,14) шог өгүүллэгт эрлэгийн элчид авлига өгөхийг оролдож буй нэгэн компанийн захирлын тухай гардаг. «Алтны шинэ уурхай маань нээгдлээ. Би амьдралын сайхныг үзмээр байна шүү дээ... Залуу сайхан эхнэр, ганц нялх үрийг минь бодож намайг нэг удаа өршөөж үзээч, элч минь. Миний оронд манай менежер Ганбаа, эсвэл манай компанийн 200 кг алтыг Номун хаанд барина уу» гэж компанийн захирал үглэн тийчлэхэд эрлэгийн элч номхрох нь бүү хэл улам ширүүлэн, эвгүй хүйтэн инээж: «Эрлэг Номун хааныг элдэв хахуульд идэгдсэн

төрийнхөө түшээд шиг бодохдоо ичиггүй байна уу? Үхлийн дараах улиралд алт шиг хэрэггүй эд байдаггүй юм» гэснээ ер бусын хүчээр ховсдож хачин нам гүм хонгилоор авч одож байгаа тухай энэ шог өгүүллэгт гардаг.

1990 оноос манай оронд өрнөсөн нийгэм, улс төрийн үйл явц ардчиллыг шог, хошин нийтлэлийн

нэгголсэдэв болгожээ. Уг сэдвээр «Тоншуул» сэтгүүлд хэд хэдэн нийтлэл гарснаас Н.Даваадашийн «Манай сумын ардчилал» (2004, №10) шог найруулал онцлог юм. Энэ нийтлэлд манай ардчилсан нийгмийн салшгүй хэсэг болоод байгаа тэмцэл, жагсаал цуглаан, эмх замбараагүй байдал, мөн эрх чөлөө хэмээх халхавчин доор газаравсанувайгүй өдөөн хатгалаг, турхи-ралтыг шоглон

«

*Ардчилал, улс төр, хүний эрх,
урлаг уран сайхан, авлига хээл
хахууль, УИХ ба нам эвсэл, хүн ба
мөнгө, баяр наадам, архи тамхи,
зах зээлийн үеийн хүний мөс чанар,
залхуу хойрго байдал
Н.Даваадашийн шог, хошин
нийтлэлийн үндсэн сэдэв байв.
Тэрээр даацтай, гүн гүнзгий утга
агуулгатай бичдэг, шог найруулал,
шог өгүүллэг, хошин ерөөл зэрэг
олон төрөл, зүйлээр
нийтлэлээ туурвидаг сэтгүүлч юм*

»

үзүүлжээ. Энэсэдвээр бичигдсэн ихэнхний тлэл Монголдард чилал нэрээр анархи, олигархуудын засаглал тогтсоныг илчлэн дэлгэсэн байдаг.

1990 оноос хойш шог, хошин бичлэгийн төрөл, зүйл шинэ шинэ хэлбэрүүдээр баяжсан. Үүнд хошин ерөөл, хошин зурхай, хошин танилцах зар, хошин үгийн сүлжээ гэх мэт бичлэгийн зүйлх амаарна.

Хүний жавхлантай сайхан амьдралын ирээдүйг бэлгэдэн зөгнөж, зонолны аз жаргалтай амьдралын хүсэл мөрөөдөл биелж бүтэхийг хүсч илэрхийлсэн нутгауянгын нэгтөрлийг ерөөл гэнэ. Ерөөл нь аманба бичгийн уран зохиол дөргөнд элгэрсэн, олон сэдэв, төрөл зүйл бүхий уламжлалт хэлбэр юм. Ерөөл үйл явдалгүй, ерөөгчийн бэлгэдэл, зөн билэг, ирээдүйн тухай хүсэл сэтгэлийг гэгээлэг сайнаар илэрхийлсэн мөрөөдлийн чанартай дүрслэлүүдээс бүрддэг. Тэгвэл хошин ерөөлд сайн сайхныг бэлгэдэн ерөөдөггүй, далд санаагаар даапаалан өгтолсон байдаг.

Хошин ерөөл 1990 оноос хойш цөөн тоотой нийтлэгдэх болжээ. Ийм ерөөлөөс Н. Даваадашийн «Орчин цагийн “топ” ерөөл» («Тоншуул», 2004, №23, 24) тун онцлог болжээ. Уг ерөөлд:

«...Орос хэлэнд шахуулж оготор болох шахсан
Англи хэлэнд атгуулж атигар болох дөхсөн
Ар Монголын хэлээрээ, алд биеийн эрдмээрээ
Ашдын дэмбэрэл бодож, ах нь ерөөлөө хэлье ээ.
Зээ! Өдрийн сайныг үндэсний зурхайчаар хэлүүлж

Сарын сайныг сад (цэцэрлэгийн)-ны зурхайчаар тогтоолгож
Урьдын явдлаа Утай Гүмбэнд засуулж
Угтах өдрийн хэргээ умрын шашинд даатгаж
Өнөөдрийн энэ өдөр өндөр харшаа барьж
Өтгөн найраа хийж өлзий хишгээ арвижуулж
Өргөн олноо дайлж байгаа
Үеийн хоёр найз маань
Өнгө зүс тунамал байна
Өмссөн зүүсэн нь ганган байна
Арван цагаан хуруунд нь Алт монет дүүрэн байна.
Араб газрын султан шиг Алтан шаахай өмссөн байна.
...Агар зандан ширээг Шүрээр хөллөж тавьсан байна.
Арслан зааны соёог Мөнгөөр тоноглож тулсан байна.
Авто машин гэдгийг цомог болгон өрсөн байна
Аваар ослын цагдааг хуаран болгон авсан байна.
Хувьтай төрсөн хоёр дүү минь Хувьчлалаар баяжсан аавынхаа
Хурааж яваа хөрөнгөөс Хувь хишгээ хүртэж
Хурдан баяжихыг зорьж Хужаа, Оросын хооронд
Худалдаа арилжаа хийж Спирт, архи дарж
Идлэг шонхор гаргаж Хар тамхи шургуулж
Халуун зэвсэг гулгуулж Гаалийн хүндэт нөхөдтэй
Гар барин мишээж Ганхахгүй төрийн “бурхи”-тай
Гагнаа холбоо зузаарч Хувь хишгээ хуваалцан
Хур баян болжээ» гэхчилэн «ерөөсөн» нь түүний даапаалан ёжлох, асуудлыг шог, хошиноор илэрхийлэх ур чадварыг харуулж байна.

Ишлэл

¹Гүндалай Ш. 1989.Шог, хошинзохиол (Л. Бадарчийнуранбүтээлийнжишээндээр).УБ.; 1981.Оносоншоглол, хошигнол, шүүмж // «Үнэн», №24; 1983.Шогдүрийгурлахуй // «Утгазохиолурлаг», №32; 1981. Чанарчухалбайна // Найманнуурынуянга. Арвайхээр; Чамбайөгүүлэгбүтээцгээ // 1972, «Хөдөлмөрийнтөлөө» сонин, №7; 1991.

Жинхэнэбадуураймалшогийнтухайшүүмж // «Өвөрхангай-70» эмхэтгэл, Арвайхээр; 1995.Инээх л сайханалба // «Бодлынсолбилцол» сонин, №39, 40 (202, 203); 1999. Л. Ванганы «Эрхиймажиг» туужидхийсэнажиглалт // Монголыннуранзохиолындээжис. 65-р боть.УБ.; 2000. Хүндсурталдсөхөрсөнамаьдрал (Шаг. Цэнд-Аюушийн «Хүлээхөрөөнийэзэгтэй» хошинроманытухай) // «Утгазохиолсудлал» эрдэмшинжилгээнийсэтгүүл, №2.

²Норовсүрэн Л. 1994.Сониныбичлэгийнтөрөл, зүйл.УБ.; 1996. Монголынтогтмолхэвлэлийнбичлэгийнтөрөл, зүйл.УБ.; 2008. Сэтгүүлзүйнбичлэгийнтөрөл, зүйл.УБ.

³Мөнхбаяр Б. 2011. Н. Даваадаш. «XX зууны монгол зохиолчид» цуврал. УБ., х. 50.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гүндалай Ш. 2005. Монгол шог, хошин өгүүллэг. УБ.
2. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
3. Зулькафиль М. 2009.Сэтгүүлчийнурчадвар. Тэргүүнботь. УБ.
4. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

5. Белинский В. Г. 1944. О Крылове: Сборникстатей и высказываний. М.
6. Виленский М. Э. 1982.Какнаписатьфельетон. М.
7. Ворошилов В. В. 2001.Журналистика. СПб.
8. 1970.Газетныежанры.(Подред. В.Д.Пельт, М.С.Черепанова, Ю.Н.Чернышёва.) М.
9. Ким М. Н. 2004.Жанрысовременнойжурналистики . СПб.
10. Мусеев В. А. 2002.Журналистика и журналисты. Киев.
11. Прохоров Е. П. 2002.Введение в теориюжурналистики. М.
12. Стрельцов Б. В. 1983. Фельетон. Изд-воБГУ. Минск.
13. Тертычный А. А. 2002.Жанрыпериодическойпечати. М.
14. Ткачёв П. И.1975.Идуна«вы»: заметки о памфлете. Минск.

Summary

This article discussed prominent changes of Mongolian writers though the ages from socialism to democracy. The changes of humoristic and satirical articles' genres, topics and specialized magazines were considered. Furthermore, we discussed humoristic and satirical writers' skills, especially on example of articles written by Davaadash Natsag. His articles, writing skills and contribution to development of journalism and society were considered.